213

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 28 өдөр Дугаар А/43 Сүмбэр сум

Залуучуудын хөгжлийн зөвлөл
байгуулах сургалт, арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтууд, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"-ийн 5.2.8 дахь хэсэг, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны "Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт олгох тухай" А/49 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний хөгжил, оролцоо, санал санаачилга, шинэлэг зан үйлийг дэмжих, эрхийг нь хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор Говьсүмбэр аймгийн Залуучуудын хөгжлийн зөвлөлийг газрын дэргэд байгуулсугай.

2.Үйл ажиллагааны хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-д нийцүүлэн зохион байгуулан үр дүнг улирал тутам тайлагнаж ажиллахыг Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б. Урангоо)-д хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Г.Мөнхдэлгэр)-д үүрэг болгосугай.

4.Сургалт арга хэмжээнд зарцуулагдах 1 020 000 (нэг сая хорин мянга) төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (Д.Оюунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОЮУНБИЛЭГ

D:/Бичиг хэрэг /тушаал

217

ГБХЗХгазрын даргын 2021 оны
.....05.....сарын.....28.....-ны өдрийн.....А/42.....
дугаар тушаалын ...1...-р хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ СУРГАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Говьсүмбэр аймаг

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Залуучуудын хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн танилцуулга	10:00-11:00 цаг	ГБХЗХГ-ын мэргэжилтэн Б. Урангоо
2	ГБХЗХГ-ын даргын 2021 оны 01/248 тоот чиглэл, Залуучуудын хөгжлийн Үндэсний зөвлөлийн 01 тогтоол, төлөвлөгөөг танилцуулга		ГБХЗХГ-ын мэргэжилтэн Б.Урангоо
3	ХНХС-ын 2021 оны А/72 дугаар тушаал, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм, түүний хэрэглээний талаар танилцуулга	11:00-12:00	Сургагч багш А.Амгаланбаатар
Цайны завсарлага 12:00-12:30			
4	Залуучуудын өнөөгийн нийгэм дэх оролцоо илтгэл	12:30-14:30	Сургагч багш Н.Идэрзориг
Үдийн завсарлага 14:30-14:40			
5	Залуучуудын хөгжлийн зөвлөлийн санал санаачилгыг хэрхэн өрнүүлэх, удирдах манлайлах арга зүй	14:40-16:40	Сургагч багш Н.Идэрзориг
6	Залуучуудын хөгжлийн зөвлөлийн удирдах зөвлөлийг сонгон батламж гардуулах	16:40-17:00	Сургагч багш А. Амгаланбаатар

2021.05.25-ны өдөр Шивээговь сум

2021.05.27-ны өдөр Баянтал сум

2021.05.28-ны өдөр Сүмбэр суманд тус тус ажиллана.

D:/Бичиг хэрэг /тушаал

ГБХЗХгазрын даргын 2021 оны
05 сарын 28-ны өдрийн 44/43
дугаар тушаалын 2-р хавсралт

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ СУРГАЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН НИЙТ ТӨСӨВ

Говьсүмбэр аймаг

№	Бүтээгдэхүүний нэр	Хэрэгцээт тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хариуцах эзэн
Сургалтанд шаардагдах бичиг хэргийн зардал					
1	Сургагч багшийн гэрээний зардал	20 цаг	50000	1 000 000	**ГБХЗХГ**
2	Батламжийн жааз	4 ш	5000	20000	
Нийт төсөв				**1 020 000**	

D:/Бичиг хэрэг /тушаал